

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/28

Өлгий

Г

Эмчилгээний бэлэн хоолыг орлогод
авч, хуваарилах тухай

Г

Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.10 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2 дахь заалт, Эрүүл мэндийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/13 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангаас хэрэгжүүлж буй Хүүхдийн хоол тэжээлийн хөтөлбөрийн хүрээнд зорилтот аймаг, дүүрэгт нийлүүлэгдэх 4,331,000 (зуун дөрвөн сая гурван зуун гучин нэгэн мянга) төгрөгийн үнэ бүхий орлогод авах 5 хүртэлх насны хүүхдийн хоол тэжээлийн цочмог дутлын эмчилгээний бэлэн хоолны эрүүл мэндийн байгууллагад хуваарилах жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Эмчилгээний бэлэн хоолыг эргэлтийн хөрөнгөөр бүртгэж, санхүүгийн тайланд тусгахыг нягтлан бодогч /Х.Лена/-д даалгасугай.

3. Хуваарилсан хүүхдийн хоол тэжээлийн цочмог дутлын эмчилгээний бэлэн хоолыг хөрөнгийн бүртгэлд авч зарцуулалт, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг холбогдох Эрүүл мэндийн байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга /А.Ерганат/-д даалгасугай.

ДАРГА



Н.САКЕН

2024 оны 04 сарын 11 өдрийн 12 тоот
тушаалын 114/137 хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГАД ХУВААРИЛАХ ЖАГСААЛТ

№	Эрүүл мэндийн төвийн нэр	Эмчилгээний хоолны нэр, төрөл	Нэг бүрийн үнэ	Тоо, хэмжээ	Хүлээн авсан хүний гарын үсэг
1	Алтай	RUTF эмчилгээний бэлэн хоол, ууттай 92 грам /нэг хайрцагт 150 ширхэг/	173,240	1	
2	Алтанцөгц			1	
3	Баяннуур			1	
4	Бугат			1	
5	Булган			1	
6	Буянт			1	
7	Дэлүүн			2	
8	Ногооннуур			1	
9	Сагсай			1	
10	Толбо			1	
11	Улаанхус			2	
12	Цэнгэл			2	
13	Цагааннуур			0	
14	Хотгор			0	
15	Жансая			1	
16	Мейрим			2	
17	Рауан			1	
18	Шипагер			2	
19	АНЭ			4	
	Нийт			25	

ХУВААРЬ ГАРГАСАН:

ЭМГ-ЫН ХООЛ ТЭЖЭЭЛ, ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ ХАРИУЦСАН

МЭРГЭЖИЛТЭН

Т. РАХАТ